



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/169

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төл малыг бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: П.Аюушжав (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

Гишүүд: Б.Батбилэг ("Хустын рашаан" Мал эмнэлгийн эзэн)

Л.Батчулуун (Малын их эмч)

С.Цэнд-Аюуш (Малын их эмч)

П.Содномбалжир ("Хутагт уулын өгөөж" мал эмнэлгийн эзэн)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

2. Төл малыг вакцинжуулах намрын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 10-наас 09 дүгээр сарын 10-ийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэн, дүн мэдээг тухай бүр Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж ("Хустын рашаан", "Хутагт уулын өгөөж")-үүдэд үүрэг болгосугай.

3. Вакцинжуулалтын ажлын зарыг малчдад хүргэж төвлөсөн газарт мал сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, тогтоосон хугацаанд вакцинжуулалтын арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэн, малчдад тус тус үүрэг болгосугай.

4. Вакцинжуулалтын ажлын явц, технологийн мөрдөлт, зохион байгуулалт, мал сүргийн хамрагдалтад байнгын хяналт тавин ажиллаж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулж, хариуцлага тооцон ажиллахыг эрх бүхий улсын байцаагч (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/